

БАНКНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЕРӨНХИЙ
НӨХЦӨЛ

ИРГЭН

2 0 2 5

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ АГУУЛГА.....	3
ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	3
ГУРАВ. ХАРИЛЦАГЧААР БҮРТГЭХ, ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭХ.....	4
ДӨРӨВ. ДЕПОЗИТ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ.....	5
ТАВ. ДАНСТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ	8
ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО,МӨНГӨН ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	8
ДОЛОО. КАРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН,ҮЙЛЧИЛГЭЭ.....	9
НАЙМ. ДИЖИТАЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	15
ЕС. ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	18
АРАВ. ХҮҮ, ХУРААМЖ	19
АРВАН НЭГ. САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	19

НЭГ. ЕРӨНХИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү "Үйл ажиллагааны ерөнхий нөхцөл" нь (цаашид **"ҮАЕН"** гэх) ГОЛОМТ банк (цаашид **"Банк"** гэх)-с иргэн, хуулийн этгээдэд мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйлчилгээ, картын болон дижитал үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах баримт бичиг юм.
- 1.2. Банк нь ҮАЕН-ийг шинэчлэх тухай бүрд www.golomtbank.com цахим хуудсанд байршуулах ба шинэчилсэн ҮАЕН нь харилцагчийн Банктай өмнө байгуулсан аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээг шинэчлэх үндэслэл болохгүй.

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. ҮАЕН-д тусгагдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1. **"Харилцагч"** гэж иргэн, хуулийн этгээд, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон, Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах этгээдийг;
 - 2.1.2. **"Ерөнхий гэрээ"** гэж Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулсан ерөнхий гэрээг;
 - 2.1.3. **"Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч"** гэж Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн дагуу асран хамгаалалтад байх хүн, харгалзан дэмжвэл зохих хүнийг асран хамгаалж, харгалзан дэмжүүлэхээр сум, дүүргийн Засаг даргын томилсон хүнийг;
 - 2.1.4. **"Дижитал суваг"** гэж Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг цахим хэлбэрээр харилцагчид үзүүлэх боломжийг олгож буй, тусгайлан тодорхойлсон нэвтрэх нэр, нууц үгээр баталгааждаг Банкны програм хангамжуудыг хэлнэ. Үүнд: Интернет банк, смарт банк, сошиалпэй аппликейшн, гэрээт байгууллагын програм хангамж;
 - 2.1.5. **"Итгэмжлэл"** гэж харилцагч өөрийг нь төлөөлж, өөрийнх

- нь нэрийн өмнөөс тодорхой үйлдэл хийх эрхийг өөр нэг этгээдэд олгосон, хуульд заасан шаардлагыг хангасан баримт бичгийг;
- 2.1.6. **"Хадгалуулагч"** гэж Банктай бүтээгдэхүүн үйлчилгээний гэрээ байгуулан мөнгөн хадгаламж нээлгэсэн харилцагчийг;
- 2.1.7. **"Хамтран өмчлөгч"** гэж мөнгөн хадгаламжийг бусад хадгалуулагчтай дундаа хамтран өмчлөх хадгалуулагчийг;
- 2.1.8. **"Мөнгөн хадгаламж"** гэж гэрээний үндсэн дээр Хадгалуулагчаас банканд хадгалуулсан үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг болон гадаад улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх мөнгөн хөрөнгийг;
- 2.1.9. **"Харилцах данс"** гэж гэрээний үндсэн дээр Банк Харилцагчид төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр нээсэн дансыг;
- 2.1.10. **"Хадгаламжийн дэвтэр"** гэж хадгалуулагчийн мөнгөн хадгаламжийн нэрийн дансны гүйлгээ, үлдэгдэл, гэрээний нөхцөлийг тэмдэглэж харуулсан өөрт нь хадгалах баримтыг;
- 2.1.11. **"Хугацаатай мөнгөн хадгаламж"** гэж Хадгалуулагч нь Банкны мөнгөн хадгаламжийн нөхцөлийг хүлээн зөвшөөрч, тодорхой хугацаа зааж, энэ хугацааны туршид бүх төрлийн зарлагын гүйлгээ хийхгүйгээр гэрээ байгуулсан мөнгөн хадгаламжийг;
- 2.1.12. **"Хугацаагүй мөнгөн хадгаламж"** гэж Хадгалуулагч нь Банкны мөнгөн хадгаламжийн нөхцөлийг хүлээн зөвшөөрч, тодорхой бус хугацаатай хадгалуулсан мөнгөн хадгаламжийг;
- 2.1.13. **"Мөнгөн хадгаламжийн авто сунгалт"** гэж хугацаатай мөнгөн хадгаламжийг тухайн бүтээгдэхүүний төрлөөр нь, тухайн дансны сунгалт хийгдэх үеийн банкны зарласан хүүг мөрдөхөөр, тодорхой хугацаа, давтамж заан мөнгөн

- хадгаламжийн хугацааг урьдчилан сунгах үйлчилгээг;
- 2.1.14. **“Шилжүүлэг”** гэж аливаа этгээдээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг;
- 2.1.15. **“КИОСК төхөөрөмж”** гэж банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг зайнаас үзүүлэх зориулалттай биет, электрон төхөөрөмж юм.
- 2.1.16. **“Депозит данс”** гэж Харилцагчийн харилцах, хадгаламжийн дансыг;
- 2.1.17. **“И-Код”** гэж Карт оролцоогүй гүйлгээ хийх буюу интернэт худалдааны гүйлгээ хийх үед тухайн гүйлгээг баталгаажуулах кодыг хэлнэ;
- 2.1.18. **“2FA” /Two-factor authentication/** гэж Google Authenticator Application дээр суурилсан хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулах 2 алхамт баталгаажуулалт бүхий 30 секунд тутамд шинэчлэгддэг код юм.
- 2.1.19. **“ОТР” /One Time Password/** гэж автоматаар үүсгэгдэх үсэг, тоо агуулсан хэрэглэгчийн нэг удаагийн нууц дугаарыг хэлнэ.
- 2.1.20. **“АТМ төхөөрөмж”** гэж Харилцагчид бэлэн мөнгө авах, гүйлгээ хийх, шилжүүлэг хийх, дансны хуулга харах болон картын бусад үйлчилгээг авах боломжтой банкны төхөөрөмжийг хэлнэ;
- 2.1.21. **“СДМ төхөөрөмж”** гэж АТМ төхөөрөмжтэй адил төстэй бөгөөд орлого хүлээн авах боломжтой банкны төхөөрөмжийг хэлнэ;
- 2.1.22. **“СРМ төхөөрөмж”** гэж АТМ төхөөрөмжтэй адил төстэй бөгөөд орлого хүлээн авахаас гадна эргээд зарлага гаргах боломжтой банкны төхөөрөмжийг хэлнэ;
- 2.1.23. **“ПОС төхөөрөмж”** гэж Банкны системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар Картаар үйлчлэгч байгууллагад байршуулсан төлбөрийн картыг хүлээн

- авагч бүхий банкны төхөөрөмжийг хэлнэ;
- 2.1.24. **“Зээл”** гэж Банкнаас гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр хүүтэй буюу хүүгүй бусад этгээдэд аливаа хэлбэрээр олгосон мөнгөн хөрөнгийг;
- 2.1.25. **“Зээлдэгч”** гэж Банкнаас зээл авсан аливаа этгээдийг;
- 2.1.26. **“Хамтран зээлдэгч”** гэж Үндсэн зээлдэгчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээсэн этгээдийг;
- 2.1.27. **“Хамтран үүрэг гүйцэтгэгч”** гэж зээлийн гэрээний дагуу зээлдэгчийн хүлээх үүргийг бүхэлд нь Банкны өмнө хүлээх этгээдийг;
- 2.1.28. **“Лоялти хөтөлбөр”** гэж банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглаж тодорхой нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд урамшуулал олгож байгаа хөтөлбөрийг хэлнэ;

ГУРАВ. ХАРИЛЦАГЧААР БҮРТГЭХ, ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭХ

3.1. Харилцагчаар бүртгэх

- 3.1.1. Банканд шинээр бүртгүүлэх харилцагч нь салбар нэгжийн цагийн хуваарийн дагуу биечлэн ирж “Харилцагчаар бүртгүүлэх хүсэлт” буюу анкет бөглөн ерөнхий гэрээ байгуулсны үндсэн дээр Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг биет салбараар авах ба дижитал сувгаар ХУР, ДАН-н баталгаажуулалтыг хийлгэж бүртгүүлэх боломжтой. Биет салбарт анкет бөглөхдөө хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Мэдээллээ өгөхийг зөвшөөрч, “Тийм” гэж бичгээр зөвшөөрөл өгнө.
- 3.1.2. Гадаад улсад байгаа харилцагч бус этгээд харилцагчаар бүртгүүлэх тохиолдолд Монгол улсын Дипломат төлөөлөгчийн газар дахь нотариатчийн үүрэг

- гүйцэтгэгчээр хувийн хэргийн бичиг баримтуудыг гэрчлүүлэн, баталгаажуулсан хувийг эх хувиар ирүүлж харилцагчаар бүртгүүлнэ. Гадаадад оршин суугаа иргэдэд зориулсан хадгаламж төрлөөр бүртгэл хийлгэх боломжтой.
- 3.1.3. Насанд хүрээгүй иргэнийг хуульд заасан дараах тохиолдлоос бусад тохиолдолд хууль ёсны төлөөлөгч төлөөлж, харилцагчаар бүртгүүлнэ. Үүнд:
- 3.1.3.1. Өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй. (Сургууль болон цалингийн байгууллагын гэрээ, тодорхойлолт зэргийг үндэслэнэ)
- 3.1.3.2. 16-18 насны иргэн данс нээлгэх тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчийн албан ёсны зөвшөөрлийг үндэслэн дангаар захиран зарцуулах эрхтэй нээж болно.
- 3.1.3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа анги нэгтгэлд ял эдэлж байгаа болон асрамжийн газарт хүмүүжиж буй насанд хүрээгүй иргэнийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын захирамжаар асран хамгаалагчаар (харгалзан дэмжигч) тодорхойлогдсон этгээд төлөөлж, банканд харилцагчаар бүртгүүлж данс нээлгэнэ.
- 3.1.4. Итгэмжлэлээр харилцагчаар бүртгүүлэх бол харилцагчаар бүртгүүлэх хүсэлтийг бөглөж баталгаат гарын үсэг зурж нотариатаар баталгаажуулан итгэмжлэлийн хамт ирүүлсэн байна. Итгэмжлэлд харилцагчаар бүртгүүлэх тухай заасан байна. Банк нь хуульд заасны дагуу харилцагчийн эрсдлийн түвшинг үнэлж, эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд цахим хэлбэрээр бүртгэж, данс нээхгүй.

3.2. Харилцагчийн мэдээлэл шинэчлэх

- 3.2.1. Банк нь харилцагчийн хувийн хэргийн мэдээллийг банканд бүртгүүлснээс хойш 5 жилд 1 удаа шинэчлэх ажлыг зохион байгуулж ажиллана.
- 3.2.2. Банк нь Салбараар үйлчилгээ авах харилцагчид аливаа данс шинээр нээх болон аливаа үйлчилгээ үзүүлэх бүрд харилцагчийн баримт бичигт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг шинэчлэн өгөхийг шаардах эрхтэй.
- 3.2.3. Харилцагч 3.2.1-д заасан мэдээллийг өгөхөөс татгалзсан бол Банк нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, гэрээг цуцлах эрхтэй.
- 3.2.4. Банк дараах тохиолдолд харилцагчийн мэдээллийг шинэчлэн авна. Үүнд:
- 3.2.4.1. Насанд хүрээгүй харилцагч 18 нас хүрч, эрх зүйн бүрэн чадамжтай болсон тохиолдолд;
- 3.2.4.2. Харилцагчийн овог, нэр, регистрийн дугаар, утас, мэйл хаяг, баталгаат гарын үсэг өөрчлөгдсөн тохиолдолд;
- 3.2.5. Харилцагч нь өөрийн мэдээллийг Банканд үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

ДӨРӨВ. ДЕПОЗИТ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Данс нээх

- 4.1.1. Депозит дансыг үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг болон гадаад улсын мөнгөн тэмдэгтээр нээлгэж төлбөр тооцоогоо гүйцэтгэх боломжтой ба Банк хуульд заасны дагуу харилцагчид данс нээхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлэн авна. Үүнд:
- Хүсэлт;
 - Гарын үсгийн маягт;
 - Хамтран өмчлөгчтэй бол Хамтран өмчлөгчийн талаарх мэдээлэл;

- Гэрээ;
- Хуульд заасан бусад;
- 4.1.2. Банк шаардлага хангасан бичиг баримтад үндэслэн харилцагчийн хүсэлтийн дагуу холбогдох бүтээгдэхүүнээр дансыг үнэн зөв, боломжит богино хугацаанд нээнэ.
- 4.1.3. Банк нь харилцагчийн нэр дээр нээгдсэн депозит дансны онцлог, төрлөөс хамааран Банкны цахим хуудсанд байршуулсан нөхцөл болон хууль тогтоомжийн дагуу хүү бодож олгоно;
- 4.1.4. Банк нь харилцагчийн нэр дээр нээгдсэн депозит дансны онцлог, төрлөөс хамааран Банкны цахим хуудсанд байршуулсан нөхцөлийн дагуу хураамж тооцно;
- 4.1.5. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Харилцагчийн дансанд олгогдох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварыг суутгаж, холбогдох татварын байгууллагад шилжүүлнэ;
- 4.1.6. Харилцагч нь депозит данстай холбоотой бүх төрлийн үйлчилгээг банкны салбар, тооцооны төв, болон дижитал сувгуудаар дамжуулан авна.

4.2. Дансанд хамтран өмчлөгч нэмэх, хасах

- 4.2.1. Мөнгөн хадгаламжийг хэд хэдэн хадгалуулагч дундаа хамтран өмчилж болох бөгөөд хамтран өмчлөгчид нь адил эрх, үүрэгтэй байна.
- 4.2.2. Нэг хадгаламжийн дансанд 3 хадгалуулагч бүртгүүлэх боломжтой.
- 4.2.3. Хамтран өмчлөгч нэмэх, хасах болон хамтран өмчлөгчдийн зарлага гаргах эрхийг Банканд хүсэлт гарган гэрээ байгуулж тодорхойлно.
- 4.2.4. Хамтран өмчлөгчийг зөвхөн хадгаламжийн дансанд нэмэх боломжтой ба дараах нөхцөлийг баримтална.
 - 4.2.4.1. Хадгаламжийн дансанд хамтран өмчлөгч нэмэх

болон хасах тохиолдолд Банкны салбарт өөрийн биеэр албан ёсны бичиг баримттайгаа ирж хүсэлт гарган гэрээ байгуулна.

- 4.2.4.2. Хамтран өмчлөгчөөр бүртгүүлэх этгээд нь Банканд бүртгэлтгүй тохиолдолд холбогдох хувийн хэргийг бүрдүүлэн харилцагчаар бүртгүүлнэ.
- 4.2.4.3. Хугацаатай болон хугацаагүй бүх төрлийн хадгаламжийн дансанд хамтран өмчлөгчөөр бүртгүүлэх боломжтой байна.
- 4.2.4.4. Хамтран өмчлөгч нэмэх болон хасуулах тохиолдолд үндсэн болон хамтран өмчлөгч банкны салбарт хамт ирж үйлчилгээг хийлгэх боломжтой байна.

4.3. Хадгаламжийн данс сунгах

- 4.3.1. Хадгалуулагч нь дараах сувгуудаар хандан хүсэлт гарган хугацаатай мөнгөн хадгаламжийн хугацааг гэрээний хамт сунгуулж болно. Үүнд:
 - 4.3.1.1. Салбар тооцооны төвд биечлэн ирж;
 - 4.3.1.2. Итгэмжлэлээр;
 - 4.3.1.3. Дижитал сувгаар;
 - 4.3.1.4. “Мөнгөн хадгаламжийн авто сунгалт”-н үйлчилгээгээр;
 - 4.3.1.5. Утсан Борлуулалтын үйлчилгээгээр;
 - 4.3.1.6. Offline Хүсэлтээр; /гадаад харилцагч/;
- 4.3.2. Хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдөр гэрээний хугацааг сунгаснаар мөнгөн хадгаламжийн хугацаат чанар алдагдахгүй байна.
- 4.3.3. Мөнгөн хадгаламжийн авто сунгах хүсэлтээр хадгаламжийн дансыг хамгийн ихдээ 3 удаа авто сунгах боломжтой байна.
- 4.3.4. Хүүхдэд зориулсан Алтантүлхүүр хадгаламжийн хугацаа

эхний удаад данс нээсэн өдрөөс хүүхдийн төрсөн өдөр хүртэл хоногоор хадгаламжийн хугацаа тогтох ба цаашид 18 нас хүртэл 1 жилээр авто сунгагдана.

- 4.3.5. Банктай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсхүл гэрээг дахин сунгуулах хүсэлт тавиагүй бол Банк хадгаламжийг хугацаагүй хадгаламжид тооцож, хүүг хугацаагүй хадгаламжийн хүүтэй адил хэмжээгээр бодно.

4.4. Дансны төлөв солих

- 4.4.1. Харилцагчийн депозит дансанд 1 жилийн хугацаанд гүйлгээ огт хийгдээгүй бол банк дансыг идэвхгүй төлөвт шилжүүлэх бөгөөд Салбар, тооцооны төв болон дижитал сувгаар дамжуулан гүйлгээ хийсэн нөхцөлд данс дахин идэвхтэй төлөвт шилжинэ.
- 4.4.2. Харилцагчийн депозит дансанд идэвхгүй төлөвт шилжсэн хугацаанаас хойш дахин 1 жилийн хугацаанд гүйлгээ огт хийгдээгүй бол банк дансыг хөдөлгөөнгүй төлөвт шилжүүлнэ. Дараах тохиолдолд дансны төлөвийг шилжүүлнэ.
- 4.4.2.1 Харилцагч Салбар, тооцооны төвд өөрийн биеэр хандсан тохиолдолд, банкны ажилтан харилцагчийн хувийн хэргийг нягтлан шалгаж, шаардлагатай мэдээллийг шинэчилсний үндсэн дээр “Депозит дансыг идэвхтэй төлөвт шилжүүлэх тухай” хүсэлтийг бөглүүлэн авч, идэвхтэй төлөвт шилжүүлнэ.
- 4.4.2.2 Дижитал сувгаар дамжуулан хөдөлгөөнгүй төлөвт шилжсэн дансанд гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн данс автоматаар идэвхтэй төлөвт шилжинэ.

4.5. Данс хаах

- 4.5.1. Харилцагч өөрийн хүчин төгөлдөр бичиг, баримт болон хадгаламжийн дэвтрийг эх хувиар авчирч Банкны салбар, тооцооны төв болон зайны сувгуудаар данс хаах боломжтой.
- 4.5.2. Банк дараах тохиолдолд дансыг хааж болно. Үүнд:
- 4.5.2.1. Харилцагч данс хаалгах хүсэлт гаргасан;
- 4.5.2.2. Харилцагчтай байгуулсан гэрээний нөхцөл дуусгавар болсон;
- 4.5.2.3. Харилцагч данс нээх үед харилцагчийн бичиг баримтын мэдээлэлд өөрчлөлт орсонтой холбоотой хүсэлт бөглөхөөс татгалзсан;
- 4.5.2.4. Харилцагчийн данс тэг болон хасах үлдэгдэлтэй бөгөөд сүүлийн 2 жил болон түүнээс дээш хугацаанд огт гүйлгээ хийгдээгүй, хөдөлгөөнгүй төлөвт шилжсэн эсвэл хөдөлгөөнгүй төлөвт шилжсэнээс хойш харилцагчийн дансанд 2 жилийн хугацаанд огт гүйлгээ хийгдээгүй иргэн харилцагчийн 20,000 (Хорин мянган) төгрөгөөс доош үлдэгдэлтэй дансуудыг хаах.
- 4.5.2.5. Энэхүү ҮАЕН-н 4.5.2.4-т заасны дагуу үлдэгдэлтэй данс хаагдсан тохиолдолд харилцагч банканд хандан үлдэгдлийг авах боломжтой;
- 4.5.2.6. Хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад үндэслэл;
- 4.5.3. Хадгаламжийн дэвтэр хаяж үрэгдүүлсэн бол тухайн үед мөрдөгдөж буй банкны бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлийн дагуу хураамж төлж нөхөн авах боломжтой.
- 4.5.4. Депозит дансны бүтээгдэхүүний онцлог, төрлөөс хамааран данс хаахад тухай үед мөрдөгдөж буй Банкны бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлийн дагуу хураамж авч болно.

- 4.5.5. Харилцагчийн данс эрх бүхий байгууллагаас битүүмжлэгдсэн, зарлага гаргах эрхгүй байгаа тохиолдолд тухайн дансыг хаах боломжгүй.

ТАВ. ДАНСТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Дансны тодорхойлолт

- 5.1.1. Дансны тодорхойлолтыг Банкны салбар нэгж, дижитал суваг болон КИОСК машинаас авах боломжтой.
- 5.1.2. Банк дараах тохиолдолд тодорхойлолт гаргаж, олгоно. Үүнд:
- 5.1.2.1. Харилцагч өөрийн биеэр хүсэлт гаргасан тохиолдолд;
- 5.1.2.2. Харилцагчийн хууль ёсны итгэмжлэгдсэн этгээд хүсэлт гаргасан тохиолдолд;
- 5.1.3. Банк нь харилцагчийн хүсэлтийн дагуу дараах тодорхойлолтуудыг гаргана.
- 5.1.3.1. Дансны тодорхойлолт;
- 5.1.3.2. Өр зээлийн тодорхойлолт;
- 5.1.3.3. Гадаадаас мөнгө шилжиж ирсэн тодорхойлолт;
- 5.1.4. Дансны үлдэгдэлтэй тодорхойлолтыг авсан тохиолдолд харилцагчийн дансанд тухайн өдөр Банк битүүмж хийж, зарлага гаргах боломжгүй болно. Тухайн битүүмж нь дараа өдрийн өглөө автоматаар чөлөөлөгдөнө.
- 5.1.5. Дансны тодорхойлолт авсан үед 5.1.4-д заасан хугацаанд хадгаламж барьцаалсан зээл авах, давхар тодорхойлолт авах, хамтран өмчлөгч нэмэх, хасах боломжгүй.

5.2. Дансны хуулга, гүйлгээ үлдэгдлийн мэдээ

- 5.2.1. Дансны хуулгыг Банкны салбар нэгж, дижитал суваг болон КИОСК машинаас авах боломжтой.
- 5.2.2. Банк дараах тохиолдолд хуулга гаргаж, олгоно. Үүнд:

- 5.2.2.1. Харилцагч өөрийн биеэр хүсэлт гаргасан тохиолдолд;
- 5.2.2.2. Харилцагчийн гаргасан хууль ёсны итгэмжлэгдсэн этгээд хүсэлт гаргасан тохиолдолд;
- 5.2.2.3. Дансны хамтран өмчлөгч хүсэлт гаргасан тохиолдолд;

- 5.2.3. Дансны хуулгыг дэлгэрэнгүй болон хураангуй хэлбэрээр Монгол, Англи хэлээр гаргах боломжтой.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Хадгалуулагч нь дараах сувгуудаар хандан хүсэлт гарган төлбөр тооцоо гүйцэтгүүлэх, мөнгөн хөрөнгө шилжүүлэх боломжтой. Үүнд:
- 6.1.1. Салбар тооцооны төвд биечлэн ирж;
- 6.1.2. Итгэмжлэлээр;
- 6.1.3. Дижитал сувгаар;
- 6.1.4. Автомат төхөөрөмжөөр /АТМ, СДМ, СРМ, Киоск/
- 6.2. Банк харилцагчтай байгуулсан гэрээ, түүний даалгавар, зөвшөөрлийг үндэслэн бэлэн болон бэлэн бус хэлбэрээр шилжүүлгийг хийнэ.
- 6.3. Банк Харилцагчийн гүйлгээг гүйцэтгэхтэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт бичгийг харилцагчаас шаардаж болно. Гүйлгээтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөөгүй тохиолдолд цаашид Банк үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- 6.4. Баримт бичгийн бүрдэл дутуу, алдаатай, зөрүүтэй, сэжигтэй тохиолдолд банк гүйлгээг цааш дамжуулахгүй.
- 6.5. Банк харилцагчийн шилжүүлгийг төлбөрийн даалгаврыг шалгасны үндсэн дээр харилцагчийн депозит дансны

- үлдэгдэл дүнд багтаан хийнэ.
- 6.6. Банк харилцагчаас хүлээн авсан төлбөрийн даалгаврыг хуульд өөрөөр заагаагүй бол хүлээн авсан дэс дарааллыг баримтлан Монголбанкнаас баталсан журамд заасан хугацаанд шилжүүлгийг хийнэ.

6.7. Банк хоорондын төлбөр тооцоо

- 6.7.1. Банк хоорондын гүйлгээг дүнгээс хамааран их болон бага дүнтэй гүйлгээ гэж ангилна. Бага дүнтэй гүйлгээг 24 цагийн турш шууд дамжуулна. Их дүнтэй гүйлгээг ажлын өдрийн 16 цагаас өмнө шилжүүлсэн тохиолдолд тухайн өдөртөө, 16 цагаас хойш шилжүүлсэн болон амралтын өдөр шилжүүлсэн тохиолдолд дараагийн ажлын өдөр хүлээн авагчийн дансанд хийгдэнэ.

Гүйлгээний төрөл	Мөнгөн дүн	Тасалбар болох цаг
Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ	0-5,000,000 төгрөг хүртэл	24/7
Банк хоорондын их дүнтэй гүйлгээ	5,000,000 төгрөгөөс дээш	Ажлын өдрүүдэд 09:00-16:00 цаг

- 6.7.2. Өөр валютын данс хооронд хийгдэх дотоодын болон олон улсын төлбөр тооцоог банкны тухайн өдрийн мөрдөж буй ханшаар тооцож, арилжаа хийнэ.

6.8. Гадаад төлбөр тооцоо

- 6.8.1. Гадаад гүйлгээ хүлээн авагчийн мэдээллийг бүрэн, зөв, гүйлгээний зориулалтыг тодорхой бичих зэрэг нь гүйлгээ саатах эрсдэлээс сэргийлэх тул харилцагч нь өөрийн улс дамнасан төлбөр тооцоог гүйцэтгэхдээ гүйлгээний мэдээллийг дэлгэрэнгүй өгөх шаардлагатай.
- 6.8.2. Банк нь Монгол улсын МУТСТ тухай хууль, Олон улсын хориг арга хэмжээ, ФАТФ-ын хориг зэрэг олон улсын

болон дотоодын аливаа хориг жагсаалтад орсон улс орон, харилцагч руу гүйлгээ шилжүүлэх болон хүлээн авахыг хориглох бөгөөд тухайн гүйлгээг цуцлах, шаардлагатай тохиолдолд мөнгийг царцаах хүртэл арга хэмжээ авч болно.

- 6.8.3. Банкнаас болон гүйлгээ дамжуулагч харилцагч банкнаас шаардсан тохиолдолд гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл, талуудын хооронд байгуулсан гэрээ, нэхэмжлэл зэрэг шаардлагатай бусад бичиг баримтыг гаргуулан авна.

ДОЛОО. КАРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

7.1. Дебит карт

- 7.1.1. Голомт банкны харилцах данстай иргэн Дебит карт захиалах боломжтой болно.
- 7.1.2. Насанд хүрээгүй буюу 7-17 насны харилцагчид карт захиалах тохиолдолд түүний хууль ёсны асран хамгаалагчтай гэрээ байгуулснаар хүүхэд залууст зориулсан дебит картын бүтээгдэхүүнийг захиалах боломжтой болно.
- 7.1.3. Харилцагч доорх сувгуудаар Дебит картыг захиалах боломжтой.
- 7.1.3.1. Банкны салбар тооцооны төв;
- 7.1.3.2. Дижитал суваг;
- 7.1.3.3. Cards.mn;
- 7.1.4. Харилцагч өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн картыг сонгон захиалах боломжтой бөгөөд тухайн картын хураамж, өдөрт гарах бэлэн, бэлэн бус гүйлгээний хэмжээ, дагалдах үйлчилгээ, бусад дэлгэрэнгүй мэдээллийн талаар доорх сувгуудаар авах боломжтой.
- 7.1.4.1. Банкны салбар тооцооны төв;

- 7.1.4.2. Голомт банкны харилцагчийн үйлчилгээний төв: 1800-1646;
- 7.1.4.3. <https://golomtbank.com/retail/cards> ;
- 7.1.4.4. <https://cards.golomtbank.com/>
- 7.1.5. Харилцагч захиалсан картаа өөрт ойр байрлах Салбар эсвэл Хүргэлтийн үйлчилгээ ашиглан цахим үнэмлэхээр баталгаажуулан үнэгүй хүлээн авах боломжтой.
- 7.1.6. Карт нь захиалагдсанаас хойш хуанлийн 1-3 хоногийн дотор хэвлэгдэн гарах бөгөөд байршлаас хамаарч 2-10 хоногт хүргэлт хийгдэнэ.
- 7.1.6.1. Улаанбаатар хотод А бүсэд 2 хоногт; Б бүсэд 3 хоногт;
- 7.1.6.2. Хөдөө орон нутагт 10 хоногт;
- 7.1.7. Харилцагч карт хүлээн авах хаяган дээрээ байгаагүй, хаяг буруу, холбогдох боломжгүй тохиолдолд 3 удаагийн оролдлогын дараа тухайн карт банкинд буцаагдах болно.
- 7.1.8. Харилцагч яаралтай карт захиалан авах боломжтой бөгөөд яаралтай карт захиалгын нэмэлт төлбөрийг төлснөөр ажлын өдрүүдэд 09:00-16:00 цагийн хооронд, карт захиалснаас хойш 1 цагийн дараа карт захиалах үед зааж өгсөн банкны салбараас хүлээн авах боломжтой.
- 7.1.9. Карт нь бүтээгдэхүүний онцлогоос хамаарч картын дугтуй, картын брошур, картын зааварчилгаа зэргийн хамт харилцагчид очно.

7.2. Кредит карт

- 7.2.1. Харилцагч нь Голомт банканд харилцагчаар бүртгүүлэн доорх нөхцөлийг хангаснаар кредит картын хүсэлт өгөх боломжтой.
- 7.2.1.1. Хадгаламж барьцаалж;
- 7.2.1.2. Тогтмол орлоготой иргэн;
- 7.2.1.3. Бизнесийн орлоготой иргэн;
- 7.2.2. Харилцагч дараах материалыг бүрдүүлж дурын салбарт

хандан хүсэлт гаргана.

- 7.2.2.1. Хадгаламж барьцаалсан кредит карт
- Цахим иргэний үнэмлэх
 - Кредит карт болон хадгаламж болон харилцах дансны валют ижил бол хадгаламжийн 85%;
 - Кредит карт болон хадгаламж болон харилцах дансны валют зөрүүтэй, хосолсон валюттай карт бол 70% хүртэлх дүнгээр зээлийн эрх тооцогдоно
 - Хүсэлт өгснөөс хойш ажлын 2 хоногийн дараа карт олгоно
- 7.2.2.2. Тогтмол орлоготой иргэн
- Цахим үнэмлэх
 - Бусад банкаар цалингаа авдаг тохиолдолд сүүлийн 1 жилийн цалингийн дансны хуулга /12 сараас бага хугацаанд ажилласан тохиолдолд тухайн ажилласан хугацааны дансны хуулга байх – 6 сараас доошгүй/
 - Бусад банк болон ББСБ-д зээлтэй тохиолдолд зээлийн гэрээ, график, зээлийн дансны хуулга
 - Хамтран зээлтэй тохиолдолд хамтран зээлдэгчийн цалингийн тодорхойлолт
 - Бусад шаардлагатай материал
- 7.2.2.3. Бизнесийн орлоготой иргэн
- Цахим үнэмлэх
 - Банкны харилцах дансны сүүлийн 1 жилийн хуулга
 - Бизнесийн үйл ажиллагаа бүртгэлтэй бол байгууллагын дүрэм, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл
 - Холбогдох гэрээ хэлцлүүд /Түрээсийн гэрээ,

- өөрийн объектод үйл ажиллагаа явуулдаг бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ болон бусад баримт бичиг/
- Бусад банк болон ББСБ-д зээлтэй тохиолдолд зээлийн гэрээ, график, зээлийн дансны хуулга
- 7.2.2.4. Тогтмол болон Бизнесийн орлоготой харилцагчийн хувьд хүсэлтийг хүлээн авч Голомт банкны Зээлийн үйл ажиллагааны дагуу шийдвэрлэнэ.
- 7.2.3. Харилцагч хүсэлтээ өгснөөс хойш Банк ажлын 2-3 хоногт судлан хариу өгнө.
- 7.2.4. Кредит карт эзэмшигч нь банктай гэрээ байгуулж, кредит картаа авч идэвхжүүлснээр картын зээлийн эрхийг ашиглах боломжтой болох ба үүнийг зөвхөн картаар дамжуулах эсвэл гэрээнд заасны дагуу банканд даалгавар, зөвшөөрөл өгөх байдлаар ашиглана.
- 7.2.5. Хуулга гарах өдөр - Өмнөх сарын гүйлгээнүүдийг нэгтгэн харилцагчийн төлөх төлбөр болон хүү хураамж тооцон нэхэмжлэл үүсгэх ерөнхий нөхцөлд заасан хугацаа
- 7.2.6. Төлбөр төлөх сүүлийн өдөр – Хуулга гарах өдрөөр нэхэмжилсэн төлбөрийг төлөх сүүлийн өдөр.
- 7.2.6.1. Ерөнхий нөхцөлд заасан уг хугацаанд харилцагч сар бүр хамгийн бага төлбөрийг заавал төлнө. Төлөөгүй тохиолдолд зээлийн ангиллын дагуу ангилал тооцогдоно.
- 7.2.6.2. Өмнөх сарын нийт төлөлт бүрэн төлөөгүй тохиолдолд уг өдрөөс эхлэн бэлэн бус гүйлгээний хүү тооцогдож эхэлнэ.
- 7.2.7. Харилцагч кредит картанд дараах төрлийн хүү, хураамжийг тодорхой хугацаанд төлнө:
- 7.2.7.1. Жилийн хураамж - Кредит картын жилийн хураамжийг карт эзэмшигч кредит картаа идэвхжүүлсний дараа жил бүр;
- 7.2.7.2. Нөхөн авалтын хураамж - Картын нөхөн авалтын хураамжийг карт эзэмшигч картаа нөхөн авалт хийлгэх хүсэлт өгөх үед;
- 7.2.7.3. Бэлэн гүйлгээний хүү - Дотоод болон Гадаад улс орнуудын АТМ, CDM-ээс бэлэн мөнгө авах эсвэл интернэт банк болон санхүүгийн байгууллагаар шилжүүлгийн гүйлгээ хийсэн тохиолдолд Бэлэн гүйлгээний хүү тооцогдох бөгөөд ашигласан өдрөөс эхлэн төлөх хүртэлх хугацаанд хүү бодогдоно;
- 7.2.7.4. Бэлэн бус гүйлгээний хүү – ПОС төхөөрөмж, онлайн гүйлгээ ашиглан худалдан авалт хийсэн тохиолдолд, бүтээгдэхүүний нөхцөлд заасны дагуу төлөөгүй хугацаанд хүү бодогдоно.;
- 7.2.7.5. Хугацаа хэтрүүлсний нэмэгдүүлсэн хүү - Кредит картын хугацаа хэтрүүлсний нэмэгдүүлсэн хүүг карт эзэмшигч төлбөр эргэн төлөх сүүлийн өдөр төлбөрөө төлөөгүй бол тооцно.
- 7.2.7.6. Зээлийн эрх хэтрүүлсний хураамж буюу Кредит картын зээлийн эрхийн хэмжээг хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдол бүрд зээлийн гэрээнд заасан хураамж тооцогдох ба дараа сарын төлбөрийн нэхэмжлэл үүсэх өдөр;
- 7.2.7.7. Энэ хэсэгт тусгагдаагүй бусад хураамжийг карт эзэмшигчийн үйлчилгээ авах тухай хүсэлт гаргаснаар тооцно.;
- 7.2.7.8. Кредит картын нөхцөлийг банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлд тусгагдсаны дагуу мөрдөнө.
- 7.2.8. Харилцагчийн сонгон авсан Кредит картын төрлөөс хамаарч хүү бодогдох өдөр болон төлөлт хийх өдрүүд харилцан адилгүй байдаг. Иймээс өөрийн картын

гүйлгээний хуулгад хамрах хугацаа болон бусад мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Картын төрөл	Картын 1 сарын гүйлгээ тооцох хугацаа	Төлбөрийн нэхэмжлэх МЕССЭЖ-р болон хуулга и-мэйлээр илгээх хугацаа	Хамгийн бага дүн болон нийт дүнгээр эргэн төлөлт хийх сүүлийн хугацаа
ЗЭС, ГАН, Ногоон Амекс	Тухайн сарын 2-оос дараа сарын 1-ний өдрийг дуустал	Дараа сарын 2-ны өдөр	Дараа сарын 15-ний дотор төлөлт хийх
Алтан Амекс Алтан Мастер Si	Тухайн сарын 4-өөс дараа сарын 3-ны өдрийг дуустал	Дараа сарын 4-ны өдөр	Дараа сарын 22-ны дотор төлөлт хийх
Платинум Виза Ворлд Мастер	Тухайн сарын 5-аас дараа сарын 4-ний өдрийг дуустал	Дараа сарын 5-ны өдөр	Дараа сарын 25-ны дотор төлөлт хийх

7.2.9. Харилцагч кредит картын төлбөрөө дараах сувгуудаар эргэн төлөх боломжтой.

- 7.2.9.1. Кредит картын AutoPay үйлчилгээнд бүртгүүлснээр - Нийт дүнгээр эсвэл доод дүнгээр тогтмол;
- 7.2.9.2. Смарт банк ашиглаж - Харилцагч та Смарт банкны Аппликейшн татан, гар утсаараа нэвтэрч орсны дараа: Кредит картаа сонгон Төлбөр төлөх хэсгийг сонгон төлөлтөө хийнэ;
- 7.2.9.3. Интернет банк ашиглаж;
 - Өөрийн кредит карт
 - Бусдын кредит карт
- 7.2.9.4. SocialPay нэхэмжлэх;
- 7.2.9.5. Өөртөө үйлчлэх банк буюу CDM (ATM) ашиглан орлого хийх;

7.2.9.6. Салбар Тооцооны төвд хандаж;

- 7.2.10. Та интернэт банк ашиглан кредит картын төлбөр төлөх болон Авто төлөлт үйлчилгээнд бүртгүүлэх зааврыг <https://www.golombank.com/help/guide> эндээс үзнэ үү.
- 7.2.11. Харилцагчид И-банк -> Гүйлгээ -> Өөрийн данс хооронд цэсээр кредит картаасаа харилцах данс руугаа бэлэн шилжүүлэг хийх боломжтой.
- 7.2.12. Харилцагч нь карт хаалгах хүсэлтээ банканд хандаж бүх төлбөр тооцоог дуусгаснаар гэрээг дуусгавар болгоно.

7.3. Виртуал карт

- 7.3.1. Виртуал картын бүтээгдэхүүнийг Голомт банканд харилцагчаар бүртгүүлж, SocialPay аппликэйшнаар дамжуулан үүсгэх боломжтой. Харилцагч дараах брендийн дебит картуудыг SocialPay аппликейшна ашиглан авч ашиглах боломжтой.
 - 7.3.1.1. ЮнионПэй
 - 7.3.1.2. Мастер карт
 - 7.3.1.3. Виза
- 7.3.2. Харилцагч дараах брендийн кредит картыг SocialPay аппликейшн ашиглан авч ашиглах боломжтой.
 - 7.3.2.1. Американ Экспресс
 - 7.3.2.2. ЮнионПэй
- 7.3.3. Та виртуал картаараа:
 - 7.3.3.1. Худалдаа, үйлчилгээний байгууллагууд дээр картгүйгээр буюу SocialPay хэтэвчээрээ QR төлбөр тооцоо хийх.
 - 7.3.3.2. Онлайн худалдааны сайтуудаас худалдан авалт хийх боломжтой. Жишээ нь: Amazon.com, Appstore, eBay, PayPal гэх мэт.
 - 7.3.3.3. Зарим онлайн худалдаанд И-Код шаарддаг. Тухайн нөхцөлд SocialPay пин кодоо оруулаарай

7.3.3.4. Онлайн гүйлгээний хуулгаа интернет банкаараа шалгах боломжтой.

7.4. АМЕХ Картын лоялти хөтөлбөр

- 7.4.1. Харилцагч Голомт банкны АМЕХ картаараа Голомт банкнаас хамтран ажиллаж буй байгууллага дээр тодорхойлсон нөхцөлийн дагуу худалдан авалт хийснээр хөтөлбөрт хамрагдан урамшуулал авах боломжтой.
- 7.4.2. Та картын Лоялти хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://loyalty.golomtbank.com> холбоосоор орж тухай бүр танилцах боломжтой.
- 7.4.3. Голомт банкны АМЕХ карт эзэмшигчид худалдан авалт тутамдаа оноо цуглуулдаг давуу талтай ба цуглуулсан оноогоо Эрхийн бичиг болгосноор Голомт банкны хамтран ажиллагч байгууллагуудад үйлчлүүлэх боломжтой байдаг. <https://loyalty.golomtbank.com/corporate?lang=mn>
- 7.4.4. АМЕХ картын цуглуулах оноо:
 - 7.4.4.1. Amex Gold – 2,000 төгрөг / 1 ам.доллар тутамд 1 оноо
 - 7.4.4.2. Amex Green – 2,500 төгрөг / 1,5 ам.доллар тутамд 1 оноо
- 7.4.5. Сар бүрийн хуулга гарах өдөр өмнөх сард цуглуулсан оноог шалгах боломжтой. <https://www.egolomt.mn/login/> холбоосоор өөрийн эрхээр нэвтрэн КАРТ -> КРЕДИТ КАРТ -> карт сонгох үед УРАМШУУЛЛЫН ОНОО хэсэгт харагдана
- 7.4.6. АМЕХ “Selects” хөнгөлөлтийн сүлжээ
 - 7.4.6.1. АМЕХ Кредит Картаар та Монгол Улсын өндөр зэрэглэлийн зочид буудал, дэлгүүр, ресторан, үйлчилгээний газруудаас хөнгөлөлт авах боломжтой
 - 7.4.6.2. Мөн та дэлхийн 75 орны 10,000 гаруй аялал жуулчлал, ресторан, зочид буудал,

тансаг зэрэглэлийн дэлгүүрээр хөнгөлөлт урамшуулалтай үйлчлүүлнэ

7.4.6.3. “SELECTS” сүлжээнд нэгдсэн байгууллагуудын жагсаалтыг <https://www.americanexpress.com/en-gb/benefits/entertainment/events> – холбоосоор үзнэ үү.

7.5. Картын дагалдах үйлчилгээ

- 7.5.1. Даатгал – Тухайн картын онцлог, төрлөөс хамааран Аяллын иж бүрэн даатгал болон Гэнэтийн ослын даатгал дагалдах боломжтой.
- 7.5.2. Дугаар сонгох – Харилцагч нэмэлт төлбөр төлснөөр картын сүүлийн 8 оронг /AMEX card сүүлийн 6 орон/ хүссэн дугаараар сонгох боломжтой
- 7.5.3. Инстолмент зээл – Өндөр дүнтэй кредит картын зарцуулалтыг тэнцүү дүнтэй хэсэгчлэн төлөх нөхцөл рүү шилжүүлэх боломжтой
- 7.5.4. Priority pass – Дэлхийн 120 орны 1700 гаруй онгоцны буудлын ВИП хүлээлгийн танхимаар нислэг хүлээх зуур үйлчлүүлж, тав тухтай аялах боломжийг олгоно.
 - 7.5.4.1. Харилцагчийн сонгон авсан картын төрлөөс хамаарч Priority Pass карт нь харилцан адилгүй байдаг. Иймээс өөрийн картын дагалдах Priority Pass картын мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Картын бүтээгдэхүүн	РР карт	РР картын нөхцөл
World Master	Дагалдана	• Карт эзэмшигч + 1 зочин Үнэгүй • Бусад зочин 35\$
Amex Gold		• Карт эзэмшигч + 1 зочин Үнэгүй • Бусад зочин 32\$ - 34\$
Платинум Виза		• Карт эзэмшигч 35\$ • Бусад зочин 35\$
Amex Green		• Карт эзэмшигч жилд 10 удаа үнэгүй • Бусад зочин 32\$ - 34\$
Премьер дебит		• Карт эзэмшигч 35\$ • Бусад зочин 35\$

Priority pass картын албан ёсны хуудас: www.prioritypass.com

7.6. Картаар гүйлгээ хийх, түүнтэй холбоотой

- 7.6.1. Харилцагч картыг хүлээн авч банкны салбар эсвэл Дижитал сувгийг ашиглан идэвхжүүлснээр картыг ашиглах боломжтой болно.
- 7.6.2. Харилцагч ATM, CDM, POS машин дээр гүйлгээ хийх бол Пин кодоо ашиглан, Online худалдааны сайтаар гүйлгээ хийх бол И-код ашиглан гүйлгээ хийнэ.
- 7.6.3. И-Код-г банкны салбар болон Дижитал сувгаар авах боломжтой.
- 7.6.4. Харилцагч ПИН код, И-Код зэргийг мартсан бол банкны салбар болон Дижитал суваг, ATM, CDM машин ашиглан солих боломжтой.
- 7.6.5. Харилцагч ПИН кодоо 3-с дээш удаа буруу оруулсан тохиолдолд карт автоматаар түр хугацаагаар блоклогдох бөгөөд Интернэт банк, смартаар онлайнаар пин сэргээх тохиолдолд шууд блок гарна. Интернэт банк, смартаар онлайнаар пин сэргээгүй тохиолдолд маргааш өдөр нь карт нь буцаад идэвхжинэ.

- 7.6.6. Харилцагч харилцах данс болон картын үлдэгдэл, хуулгаа тогтмол шалган хянах бөгөөд гадаад, дотоодод зөвшөөрөлгүй зарлага гарсан, давхар хасагдсан, асуудалтай гүйлгээ хийгдсэн даруйд банканд мэдэгдэж, картаа түр хаалгах үүрэгтэй,
- 7.6.7. Олон улсын эрхтэй картаар бусад валютаар төлбөр тооцоо хийхэд картын төрөл, гүйлгээ нэхэмжлэгдсэн өдрийн ханш, тухайн картаар үйлчлэгч байгууллагын банкны ханш, “Виза Ворлдвайд”, “Мастеркарт Ворлдвайд” “ЮнионПэй Интернэйшнл”, “Американ Экспресс” байгууллагуудын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан гүйлгээний ханш тооцогдоно.
- 7.6.8. Харилцагч ПОС машинаар төлбөр тооцоо хийхдээ дараахыг анхаарах шаардлагатай.
 - 7.6.8.1 Кассын ажилтан картыг давхар уншуулах, картын дугаарыг тэмдэглэх,
 - 7.6.8.2 ПИН код асуух зэрэг сэжиг бүхий үйлдэл ажиглагдвал гүйлгээ хийхээс татгалзаж, банканд мэдэгдэх
 - 7.6.8.3 Гүйлгээний баримтанд гарын үсэг зурахаасаа өмнө гүйлгээний дүн, картын дугаар, он сар зөв эсэхийг шалгах
 - 7.6.8.4 Гүйлгээг буцаасан тохиолдолд буцаалтын баримтыг авч, хадгалах
- 7.6.9. Харилцагч ATM-р гүйлгээ хийхдээ дараахыг анхаарах шаардлагатай
 - 7.6.9.1 Банкны логогүй, харуул хамгаалалтгүй байршсан ATM-р үйлчлүүлэхгүй байх
 - 7.6.9.2 ATM-д нэмэлт камер, төхөөрөмж байгаа эсэхийг шалган, сэжигтэй санагдсан тохиолдолд үйлчлүүлэхгүй байх
 - 7.6.9.3 ПИН кодоо солихдоо өөрт хамааралтай бусад мэдэхэд амар дугаараар солихгүй байх

- 7.6.10 Харилцагч Онлайннар худалдан авалт хийхдээ
- 7.6.10.1 Хамгаалалтгүй онлайн сайтын линк /холбоос/ нь улаан өнгөтэй <https://> эсвэл <http://> байдаг тул картын мэдээллээ оруулахгүй байх
- 7.6.10.2 Веб сайт нь дараах лого бүхий нууцлалтай эсэхийг шалгах



- 7.6.11 Харилцагч зөвшөөрөлгүй гүйлгээ гарсан даруйд банканд бүртгэлтэй хаягаас хандан дараах сувгуудаар картыг түр, эсвэл бүр хаалгах боломжтой
- 7.6.11.1 Банкны салбар
- 7.6.11.2 Дижитал суваг
- 7.6.11.3 Харилцагчийн үйлчилгээний төв: +976 1800 1646
- 7.6.11.4 Онлайн туслах – Facebook chatbot messenger
- 7.6.11.5 Мессеж/Viber, Wechat, WhatsApp, Kakao +976 9944 1646
- 7.6.11.6 И-мэйл – mail@golomtbank.com
- 7.6.12 Харилцагч та өөрийн данс болон картаар хийгдэж байгаа гүйлгээний эрсдэлээс сэргийлэх, өөрийн мэдлэгийг сайжруулах үүднээс <https://www.golomtbank.com/help/tip> хаягаар орж байгаа мэдээлэлтэй тухай бүр танилцаж байна уу.

НАЙМ. ДИЖИТАЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

- 8.1 Интернэт банкны үйлчилгээ
- 8.1.1 Интернет банк нээх хүсэлтийг банкны салбарт өөрийн биеэр очиж гаргах ба холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн өгч, гэрээ хийж, гарын үсэг зурж баталгаажуулснаар интернет банкаар үйлчлүүлэх

боломжтой болно. Банк харилцагчийн хүсэлт болон тухайн үед мөрдөгдөж буй бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг харгалзан харилцагчийн интернет банкныг нээж, эрхийн тохиргоог хийнэ.

- 8.1.2 Голомт банкны харилцагчийн хувьд онлайннар интернет банк нээх боломжтой ба интернет банк нээснээс хойш 3 сарын дотор банкны салбарт хандаж шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгч, гэрээ хийж, гарын үсэг зурж баталгаажуулснаар интернет банкны эрхийг баталгаажуулах боломжтой. Дээрх үйлдлийг хийгээгүй тохиолдолд 3 сарын дараа харилцагчийн интернет банк зөвхөн харах эрхрүү шилжинэ.
- 8.1.3 Харилцагч Интернэт банкны гүйлгээний эрхийн хэмжээг өөрчлөх хүсэлтийг банкны салбар болон дижитал сувгаар гаргах боломжтой.
- 8.1.4 Харилцагч интернет банк ашиглан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар авах боломжтой ба бүтээгдэхүүний нөхцөл, гэрээг зөвшөөрсөн нь харилцагчийн интернет банкны гүйлгээний нууц үгээр /И-токен/ баталгаажих бөгөөд гүйлгээний нууц үгийг /И-токен/ баталгаат гарын үсэг зурсантай адил хүчинтэйд тооцно.
- 8.1.5 Интернэт банкны нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, батлах нууц үг, и-код, и-токен төхөөрөмж зэрэг нь Харилцагчийн банкин дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, Харилцагчийн хүсэл зоригийн илэрхийллийг баталгаажуулахад хэрэглэгдэх баталгаат гарын үсгийн маягтын адил хүчин төгөлдөр байна. Харилцагч нь өөрийн нэвтрэх нууц үг болон батлах нууц үгийг хагас жил тутамд шинэчилж байна.
- 8.1.6 Харилцагч интернет банкны аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах давхар баталгаажуулалтыг ашиглах боломжтой. Үүнд:

- 2FA - Ухаалаг утсандаа Google authenticator аппликейшн татаж, интернет банктайгаа холбосноор дахин давтагдашгүй нэг удаагийн нууц кодыг нэвтрэх бүрд ашиглах боломжтой болно.
 - Токен – Төхөөрөмжийг интернет банкиндаа холбосноос дахин давтагдашгүй 6 оронтой дугаарыг нэвтрэх бүрд ашиглах боломжтой болно. Харилцагч банкны салбарт өөрийн биеэр очиж төхөөрөмж авах хүсэлт өгнө.
- 8.1.7 20 сая төгрөгөөс дээш эрхтэй иргэний интернет банк хэрэглэгчдийн хувьд заавал давхар баталгаажуулалт ашиглана.
- 8.1.8 Харилцагч интернет банкуугаа нэвтрэхдээ ашигладаг төхөөрөмжүүдийг бүртгэх боломжтой ба бүртгэлгүй төхөөрөмжөөс нэвтрэх үйлдэл хийхэд нэг удаагийн OTP нууц дугаараар баталгаажуулна. Тус нууц дугаар харилцагчийн бүртгэлтэй утасны дугаарт, имэйл хаягруу илгээгдэнэ. /Yahoo мэйл хаягруу илгээх боломжгүй./ Түүнчлэн Интернэт банкны “Хувийн тохиргоо”- “Хандалтын түүх” цэсээр хамгийн сүүлд нэвтэрсэн 5 төхөөрөмжийн мэдээллийг харах боломжтой.
- 8.1.9 Харилцагч нь өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, батлах нууц үгийг нууцлах, эдгээр мэдээллийг бусдад алдахаас сэргийлэх, баталгаат и-мэйл хаяг болон утасны дугаарыг бусдад ашиглуулахгүй байх хувийн мэдээлэлд өөрчлөлт оруулах боломжийг бусдад олгохгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс шалтгаалан Харилцагчид учирсан хохирлыг Банк хариуцахгүй.
- 8.2 Смарт банк аппликэйшн
- 8.2.1 Харилцагч нь Интернэт банкны эрх нээлгэсэн тохиолдолд аппликэйшнийг ашиглах боломжтой болох ба өөрийн Интернэт банкны нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг ашиглан Смарт банк руу нэвтэрч орно.
- 8.2.2 Смарт банк аппликэйшнийг ашиглахад харилцагчийн гар утас нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 8.2.2.1 IOS үйлдлийн системийн хувилбар нь 12 болон түүнээс дээш байх
- 8.2.2.2 Android үйлдлийн системийн хувилбар нь 6 болон түүнээс дээш байх
- 8.2.3 Аппликэйшнээр та Голомт банкинд бүртгэлтэй данс болон картын мэдээллүүдээ харах, тодорхой төрлийн гүйлгээ хийх, шинэ данс нээх эсвэл хаах, дата нэгж авах, хэрэглээний төлбөрөө төлөх, захиалгат шилжүүлэг бүртгэх, изи инфо үйлчилгээнд бүртгүүлэх, сар сарын орлого зарлагын график харах, давхар баталгаажуулалт тохируулах, хувийн мэдээллээ шинэчлэх гэх мэт үйлчилгээнүүдийг авах боломжтой.
- 8.2.4 Смарт банкаар гүйлгээ хийхэд дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:
- 8.2.4.1 Өдрийн гүйлгээний лимит нь Голомт банкны ерөнхий нөхцөлийн дагуу хязгаарлагдана. Өөрийн данс хооронд лимит хамаарахгүйгээр хүссэн дүнгээр гүйлгээ хийх боломжтой.
- 8.2.4.2 Батлах нууц үг нь гүйлгээ хийх үед шаардах нууц үг бөгөөд тодорхой лимит дотор гүйлгээ хийхэд танаас батлах нууц үг шаардахгүй гүйлгээ шууд хийгдэнэ. Харин тухайн лимитээс дээш дүнтэй гүйлгээ хийх үед батлах нууц үгээр баталгаажуулах шаардлагатай.
- 8.2.5 Харилцагч та утсан дээрээ хурууны хээ эсвэл face id ашигладаг бол Смарт банк аппликэйшн дээрээ тохируулснаар нэвтрэх нууц үгний оронд баталгаажуулан хялбар нэвтрэх боломжтой.

8.3 СошиалПэй үйлчилгээ /SocialPay app/

- 8.3.1 СошиалПэй аппликейшнаар дамжуулан харилцагч нь бусад харилцагчид руу өөрийн гар утасны дугаараар дамжуулан Голомт банкны данс хооронд төлбөр тооцоо гүйцэтгэх, өөрийн төлбөрийн картыг бүртгүүлэх, картын төлбөр тооцоо хийх, банк хоорондын гүйлгээ хийх, QR ашиглан дотоодын болон олон улсын гүйлгээ хийх болон Голомт банкны карт захиалах боломжтой.
- 8.3.2 СошиалПэй аппликейшнаар дамжуулан үзүүлж буй үйлчилгээг харилцагчийн утасны дугаар, харилцагчийн хүчин төгөлдөр бичиг баримт, 4 оронтой нууц дугаараар баталгаажуулна.
- 8.3.3 Харилцагч та утсан дээрээ хурууны хээ эсвэл face id ашигладаг бол Сошиал пэй аппликэйшн дээрээ тохируулснаар нууц дугаарын оронд ашиглах боломжтой.
- 8.3.4 Харилцагч өөрийн интернэт банкны эрхээрээ СошиалПэй аппликейшн рүү нэвтрэн үйлчилгээ авах боломжтой байна.
- 8.3.5 7-18 насны хүүхдүүдийн хувьд СошиалПэй-н хүүхдэд зориулсан хувилбар болох СошиалПэй Жуниорыг зөвхөн ашиглах боломжтой.

8.4 Мобайл банкны үйлчилгээ

- 8.4.1 Мобайл банкны үйлчилгээ нь Голомт банканд бүртгэлтэй гар утасны дугаарт суурилсан банкны төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээг хэлнэ.
- 8.4.2 Мобайл банкны үйлчилгээгээр төлбөр тооцоо гүйцэтгэх тохиолдолд мобайл банкны нууц үгийг Харилцагчийн гарын үсгийн баталгаатай адилтгаж үзнэ.
- 8.4.3 Голомт банкны данс хооронд болон арилжааны бусад банкны данс руу гүйлгээ хийх нэг өдөрт гүйцэтгэх гүйлгээний хэмжээ нь хязгаарлалттай байх бөгөөд нэг

өдөрт гүйцэтгэх боломжтой гүйлгээний хэмжээг Банкны цахим хуудсанд байршуулсан үйлчилгээний нөхцөлөөр тодорхойлно.

- 8.4.4 Мобайл банкны үйлчилгээний хураамжийн нөхцөл нь банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдоно.

8.5 Изи инфо

- 8.5.1 Харилцагчийн бүх төрлийн орлого, зарлагын мэдээллийг бүртгэлтэй и-мэйл хаяг болон гар утсанд мессежээр хүргэх үйлчилгээ юм.
- 8.5.2 Иргэн харилцагч нь өөрт ойр байрлах салбарт болон интернет банк, смарт банкаар үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой. Изи инфо үйлчилгээ нь хугацаагүй ба хүссэн үедээ уг 3 сувгийн аль нэгээр дамжуулан үйлчилгээгээ цуцлах боломжтой.
- 8.5.3 Изи инфо үйлчилгээнд бүртгүүлсэн гар утасны дугаар / и-мэйл хаягаа өөрчилсөн тохиолдолд яаралтай банканд хандан мэдээллээ шинэчлэх шаардлагатай.
- 8.5.4 Изи инфо үйлчилгээнд бүртгүүлснээр дансны мэдээллээ түргэн шуурхай хүлээн авч дансаа тогтмол хянах, аливаа гүйлгээтэй холбоотой эрсдэлээс сэргийлэх болон санхүүгийн гүйлгээгээ цаг алдалгүй хянах боломжтой.

8.6 Захиалгат шилжүүлэг

- 8.6.1 Банк харилцагчийн данснаас хүлээн авагчийн данс руу хүссэн мөнгөн дүн бүхий захиалгын гүйлгээг тодорхой давтамжийн дагуу автоматаар хийх үйлчилгээг хэлнэ.
- 8.6.2 Иргэн харилцагч нь өөрт ойр байрлах салбарт болон интернет банк, смарт банкаар үйлчилгээнд бүртгүүлэх болон цуцлах боломжтой.
- 8.6.3 Захиалгат шилжүүлэг үйлчилгээ нь өдөр бүр болон сар бүр гэсэн гүйлгээний давтамжтай байна.

- 8.6.4 Хүлээн авах дансны хувьд Өөрийн дансруу, Дансны дэвтрийн хадгалсан данс руу, Дурын данс руу/бусад банк/ гэсэн сонголттой байна.
- 8.6.5 Шилжүүлэгч данс нь үндсэн данс, дотоодын болон ОУ-н эрхтэй картын харилцах данс, хугацаагүй хадгаламжийн данс гэсэн бүтээгдэхүүний төрөлтэй байна.
- 8.6.6 Хүлээн авагч данс нь үндсэн данс, дотоодын болон ОУ-н эрхтэй картын харилцах данс, хугацаагүй хадгаламжийн данс болон орлого хүлээн авах боломжтой бүх төрлийн хугацаатай хадгаламжийн дансууд байна.
- 8.6.7 Бүртгэлийн хураамжгүй байх ба гүйлгээнээс хамаарч гүйлгээний хураамж авна.

8.7 Лоялти хөтөлбөр

- 8.7.1 Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглаж тодорхой нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд урамшуулал олгож байгаа хөтөлбөрийг хэлнэ
- 8.7.2 Урамшуулалт хөтөлбөр нь Голомт банкны лоялти системээр дамжуулан авто хийгдэх бөгөөд дараах төрлөөр олгогдоно Үүнд:
 - 8.7.2.1 Оноо
 - 8.7.2.2 Тохирлын эрх
 - 8.7.2.3 Бэлэн мөнгө буцаан олголт
 - 8.7.2.4 Банкны бүтээгдэхүүн бүхий дижитал эрхийн бичиг
 - 8.7.2.5 Хамтрагч байгууллага дээр ашиглах дижитал эрхийн бичиг
- 8.7.3 Голомт банкны лоялти системээс харилцагчийн урамшууллын дансыг авто үүсгэж хөтөлбөрөөс олгогдсон урамшууллыг олгодог байна.
- 8.7.4 Харилцагч лоялти хөтөлбөртэй холбоотой доорх сувгуудыг ашиглаж мэдээлэл авах, урамшуулалт

хөтөлбөрт хамрагдах, олгогдсон урамшууллыг ашиглах боломжтой байна.

- 8.7.4.1 Голомт банкны салбар
- 8.7.4.2 <https://loyalty.golomtbank.com/>
- 8.7.4.3 SocialPay application

ЕС. ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

9.1 Зээлийн хүсэлт гаргах

- 9.1.1 Харилцагч хүсэж буй зээлийн төрлөөс хамааран зээлийн хүсэлтийг дараах сувгуудаар гаргаж болно. Үүнд:
 - 9.1.1.1 Банкны салбар
 - 9.1.1.2 Банкны дижитал суваг
- 9.1.2 Зээлийн бүтээгдэхүүний төрөл, онцлогоос хамааран зээлдэгчид тавих шаардлага болон бүрдүүлэх материалын бүрдэл өөр өөр байж болно. /www.golomtbank.com цахим хуудсанд байршуулсан мэдээллээс харах боломжтой/

9.2 Зээлийн хүсэлт шийдвэрлэх

- 9.2.1 Банк харилцагчийн санхүүгийн байдал, зээл төлөх чадварыг Банкны дотоод дүрэм, журмын дагуу тооцоолж, шалган зээлийн хэмжээг тогтооно.
- 9.2.2 Банк нь зээлдэгчийн авах боломжтой зээлийн хэмжээ болон зээлийн шийдвэрийг харилцагчид мэдэгдэнэ.
- 9.2.3 Зээлдэгчид зээлийн олголт хийсэн тухай бүрд банк “Зээлийн мэдээллийн сан”-д “Зээлийн мэдээлэл”-г мэдээлнэ.

9.3 Зээлийн ашиглалт

- 9.3.1 Зээл нь тодорхой зориулалттай байх бөгөөд Банк зээлдэгчээс зээлийг зориулалтын дагуу ашиглахыг шаардах эрхтэй,

- 9.3.2 Зээлийн бүтээгдэхүүний онцлог төрлөөс хамааран зээл олгогдсон өдрөөс харилцагчтай гэрээгээр тохиролцсон хувь хэмжээгээр зээлийн хүү бодогдож эхэлнэ.
- 9.3.3 Зээлдэгч банкт байгуулсан гэрээгээр тохиролцсон эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээл, хүүгийн төлбөрийг төлөх үүрэгтэй.

9.4 Хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч

- 9.4.1 Зээл нь хоёр ба түүнээс дээш Зээлдэгчтэй бол тэдгээрийг хамтран зээлдэгчид тооцох ба зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн аль ч Зээлдэгчээс Банк шаардах эрхтэй байна. Зээлийн олголт, зарцуулалтыг аль нэг Зээлдэгчийн нэр дээр хийж гүйцэтгэх нь хамтран зээлдэгчийг зээлийн гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд Зээлдэгч болон хамтран зээлдэгч нарын хооронд үүсэх зээлийн ашиглалт, зарцуулалт, буцаан төлөлттэй холбоотой харилцаа хамтран зээлдэгчийн зээлийн гэрээгээр хүлээх эрх, үүргийн харилцаанд нөлөөлөхгүй байна.
- 9.4.2 Хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээлийн гэрээний дагуу зээлдэгчийн хүлээх үүргийг бүхэлд нь Банкны өмнө хүлээх бөгөөд Банк нь зээлийн гэрээгээр бий болсон аливаа үүргийн гүйцэтгэлийг зээлдэгч болон хамтран үүрэг гүйцэтгэгчийн алинаас ч шаардаж болно.

- 10.3 Бүтээгдэхүүн үйлчилгээний хүү, шимтгэлийн нөхцөлийн мэдээллийг Банкны www.Golomtbank.com цахим хуудаснаас дэлгэрэнгүй харах боломжтой.
- 10.4 Дансны үйлчилгээний хураамжийг Харилцагчийн данснаас суутгаж төлүүлнэ.

АРВАН НЭГ. ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 11.1 Банк харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйл ажиллагаатай холбоотой гомдол санал хүсэлтийг дараах сувгуудаар хүлээн авч шийдвэрлэнэ. Үүнд:
- 11.1.1 Банкны салбар
- 11.1.2 Харилцагчийн үйлчилгээний төв: 1800-1646 дугаар /24 цаг нээлттэй/, гадаадаас холбогдох /viber,wechat, whatsapp,kakao/ +976-99441646 дугаар
- 11.1.3 Банкны цахим хуудас болон сошиал сувгуудаар
- 11.1.4 Банкны www.golomtbank.com цахим хуудас
- 11.1.5 Банкны фэйсбүүк хаяг www.facebook.com/GolomtBank/
- 11.1.6 Банкны твиттер хаяг Банкны твиттер хаяг www.twitter.com/Golomtbank
- 11.1.7 Банкны цахим шуудангийн хаяг internetbank@golomtbank.com, mail@golomtbank.com

АРВ. ХҮҮ, ШИМТГЭЛ

- 10.1 Банкны хүү, шимтгэл нь үйлчилгээ үзүүлж буй сувгаас хамааран салбар нэгж болон дижитал суваг гэсэн ялгаатай байна.
- 10.2 Дижитал сувгаар олгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь харилцагчид хүү болон шимтгэлийн хувьд илүү таатай нөхцөлтэй.